

Маргааны товч

Татварын ерөнхий газрын харьяа Том татвар төлөгчийн газрын Татварын хяналт, шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч нар “Баялагжонш” ХХК-ийн 2018-2021 оныг дуустал хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн НА-21220000036 дугаар нөхөн ногдуулалтын актаар 6,085,684,53.36 төгрөгийн нөхөн татвар, 1,825,705,360.61 төгрөгийн торгууль, 1,017,687,829.17 төгрөгийн алданги, нийт 8,929,077,725.14 төгрөгийн төлбөр тогтоожээ.

Нэхэмжлэгчээс дээрх нөхөн ногдуулалтын актыг эс зөвшөөрч, хүчингүй болгуулах үндэслэлээ “... татварын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан гаргаж, тухай бүр төлж байсан, татварын тайланд туссан гэрээний үнийг баримтлаагүй, аж ахуй нэгжид ашигтай Засгийн газрын тогтоол болон жоншны хүчин төгөлдөр MNS стандартыг огт хэрэглээгүй, жоншны үнэ тогтоодог бирж байхгүй, жонш нь биржийн бус бүтээгдэхүүн тул олон улсын аль ч бирж дээр үнэ зарладаггүй, хувийн www.indmin.com гэсэн цахим хаяг дээрх үнийг олон улсын зах зээлийн үнэ гэж үзэхгүй, албан бус эх сурвалж, манай компанид харилцан хамаарал бүхий этгээдийн асуудал байхгүй тул жишиг үнийн аргыг ашиглах байсан, АМНАТ төлөгдсөн жоншны бүтээгдэхүүн дээр дахин АМНАТ төлбөр ногдуулж нэг төрлийн татварыг давхардуулан ногдуулж байгаа нь татварын хууль тогтоомжид нийцэхгүй, 3 төрлийн жоншийг ОХУ-руу экспортолдог, гэрээгээр нийлүүлсэн үнэ 205 доллар, нийлүүлсэн жоншны жин, тонны хэмжээгээр төлбөр дансаар орж ирдэг, www.indmin.com сайтын жоншны ханш нь Тяньжин хотын ханш, манай компани жоншоо 205 доллароор экспортолсон хэр нь 365 доллароор тооцон татвар төлөхөөр болсон, Цэцээс хүчингүй болгосон Засгийн газрын тогтоолыг хэрэглэсэн, зах зээлийн үнэ тогтоох аргачлалаар хуулийн этгээдүүдэд хэрэглэх журмын дагуу маш их татварын ачаалал үүрүүлж, татан буугдах, дампуурах, зах зээлээс шахагдах эрсдэлд оруулсан, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.14-т заасан эх үүсвэрийг ашиглаж, нөхөн ногдуулалтын акт тавьсан нь Татварын ерөнхий хууль, Захиргааны ерөнхий хуулиудад нийцэхгүй, ...” гэж маргажээ.

Харин хариуцагчаас “... нэхэмжлэгч компани 2018-2021 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн “Х” тайлан тайлагнасан, хяналтын шалгалтад хамрагдах хугацаанд 80 мянга орчим тонн жонш экспортолсон, гаалийн мэдээ, гаалийн лабораторийн дүгнэлтээр ямар ангиллын жонш экспортолсон тогтоогддог, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг огт тайлагнаж байгаагүй, татвар төлөгч тайлангаар төлбөрөө үнэн зөв ногдуулсан гэж үзэх боломжгүй, Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2014 оны 342 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2019 оны 465 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-д заасныг үндэслэн тус компанийн экспортод гаргасан жоншинд ашигт малтмалын төлбөр ногдуулсан, Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасны дагуу хяналт шалгалт хийж, нөхөн ногдуулалтын акт үйлдсэн, төрийн өмчийг ашиглуулсны төлөө авах төлбөрөө тогтоож байгаа ...” гэж нэхэмжлэлийг эс зөвшөөрөн хариу тайлбар гаргажээ.